



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 143

Номгон

“Элэг бүтэн Баянхонгор” аймгийн
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөр, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 28 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Элэг бүтэн Баянхонгор” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



011.104

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын
29-ний өдрийн 143 дугаар тогтоолын хавсралт



**“ЭЛЭГ БҮТЭН БАЯНХОНГОР”
АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусийн голомтыг 2020 он гэхэд устгаж, халдвартын тархалтыг таслан зогсоох “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж заасан. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүн амын дунд хепатитийн вирусийн халдвартын тархалтыг хязгаарлаж, вируст хепатитээс үүдэлтэй элэгний хорт хавдар, хатуурлын шалтгаант нас баралтыг бууруулах юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр дэлхий дахинд 520 сая гаруй хүн вируст хепатитийн архаг халдвартай, үүнээс 1.45 сая хүн нь жил бүр уг өвчинээс үүдэлтэй элэгний хатуурал, хорт хавдраар нас барж, вируст хепатитийн өвчлөл дэлхийд хамгийн их тархсан халдварт өвчний нэг болсон төдийгүй эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал юм. Вируст хепатитийн шалтгаант нас баралтын 48 хувийг В вируст, 48 хувийг С вируст, 4 хувийг А, Е вируст халдварт тус тус эзэлж байна.

Монгол Улс нь 10000 хүн амд бүртгэгддэг элэгний хавдрын нас баралтаар дэлхийд нэгдүгээр байранд ордог бөгөөд энэ нь дэлхийн дунджаас 6 дахин их байна. Хавдар судлалын үндэсний төвийн 2013 оны статистик мэдээллээр Монгол улсад 200,000 хүн архаг С вирусийн халдвартай буюу тархалтын түвшин 6.8 хувьтай гэж тооцоолсон байна. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол улсын 40-өөс дээш насны хүн амын дундах хепатитийн В, С, D вирусийн халдвартын тархалтыг тогтоох судалгаагаар хепатитийн С вирусын халдварт хүн амын дунд 36.4 хувь байна гэж судалгааны тайланд тусгагдсан байна.

Манай улсад эрэгтэйчүүдийн дундах элэгний хорт хавдрын өвчлөл дэлхийн дундаж түвшнээс 8 дахин, эмэгтэйчүүдийн дундах элэгний хорт хавдрын өвчлөл 16 дахин их, элэгний хорт хавдар нь нийт хорт хавдрын өвчлөлийн 37.7 хувь, хорт хавдрын шалтгаант нас баралтын 43.3 хувийг эзлэн тэргүүлж байна. Сүүлийн арван жилд элэгний хорт хавдрын нас баралт Монгол улсад нэмэгдэж байгаа бөгөөд элэгний өмөн болон хатуурлын улмаас жилд дунджаар 2600 хүн буюу өдөр бүр

долоон хүн элэгний хорт хавдар, хатуурлын улмаас нас барж байна. Элэгний эмгэг нь манай улсын нийт нас бааралтын 15%-ийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд өнөөгийн байдлаар 1600 гаруй иргэн хепатитын В, С вирусийн халдвартай гэж бүртгэгдсэн, 2016 онд Элэг төв, Өвчтөн нийгмийн төлөөлөл төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Эрүүл элэг” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд анхан шатны нэгжүүдийг түшиглэн В, С вирусийг захын цусанд илрүүлэх өвөрмөц мэдрэг 6000 тестийг тавихад хепатитын С вирустэй 664 хүн, В вирустэй 392 хүн, В, С вирус хавсарсан 21 хүн илэрч, хамрагдсан хүн амын 18 хувьд халдвартай илэрсэн байна. Аймгийн 83 мянган хүн амд дээрхи хийгдсэн судалгааны тархалттай харьцуулахад 14 мянга орчим хүн хепатитийн халдвартай байх магадлалтай байна. Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн 1600 гаруй В, С вирустэй иргэдийн 68.3 хувь эмэгтэйчүүд байна. Жилд 120 орчим хавдар бүртгэгдэж, үүний 40-50 хувь элэгний хорт хавдар оношлогдож, 115 орчим хавдрын нас бааралтын 40-45% нь элэгний хорт хавдрын нас бааралт бүртгэгджээ. Дээрхи тоо баримтаас хараад бүртгэгдсэн өвчлөлийн дотор эмэгтэйчүүд давамгайлж байгаа хэдий ч, нас бааралтын тохиолдлын 55% нь эрэгтэйчүүд байгаа нь эрчүүдийн дунд тархалт өндөр байгаа, эмнэлэгт ханддаггүй нь харагдаж байна.

Иймд хепатитийн вирусийн халдвартын тархалтыг зогсоох, оношилгоо, эмчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, уг үйл ажиллагаанд бусад салбарын болон орон нутгийн шийдвэр гаргагчид, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгж, иргэний үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, хепатитийн В, С вирусын халдвартыг илрүүлэх, эмчлэн эдгэрүүлэх зорилгоор “ЭЛЭГ БҮТЭН БАЯНХОНГОР” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1 Хөтөлбөрийн зорилго

Аймгийн хүн амын дундах вирусийн халдвартын тархалтыг хязгаарлан, хепатитийн В, С вирусийн халдвартын шинэ тохиолдлыг 2020 он гэхэд таслан зогсоож, хепатит вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас бааралтыг эрс бууруулна.

2.2 Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Хүн амыг хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалтыг өргөжүүлэн, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх замаар тандалт, халдвартын хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.

Зорилт 2. Аймгийн хэмжээнд хепатит вирусийн халдварт, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээний чанартай тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлнэ.

Зорилт 3. Хепатитийн вирусийн халдварт, элэгний хатуурал, хорт хавдрын оношилгоо эмчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, үр дүнг эмнэл зүйн тусlamж, үйлчилгээнд нэвтрүүлнэ.

Зорилт 4. Хепатитийн вирусийн халдвартын өвчлөл, элэгний хорт хавдрын эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжиж ажиллана.

2.3. Хэрэгжүүлэх хугацаа: Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа

3.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.1.1 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 1. Хүн амыг хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах

3.1.1.1. Вируст хепатитээс урьдчилан сэргийлэх, халдвартархад эрсдлийг бууруулах чиглэлийн мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг цогц байдлаар хэрэгжүүлэх төлөвлөлтийг гарган, үр дүнг тооцох.

3.1.1.2. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийгмийн эрүүл мэндийн цуврал нэвтрүүлэг, баримт болон богино хэмжээний кино хэлбэрээр вируст хепатитаас сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааг тасралтгүй хийх.

3.1.1.3. Шаардлагагүй тариа хийлгэх, бодит шалтгаангүйгээр эмнэлэгт хэвтэх зэрэг эрсдэлт хүчин зүйлсээс ард иргэдийг зайлсхийх талаар олон нийтэд болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад сургалт, сурталчилгаа явуулах;

3.1.1.4. Өсвөр үеийнхэн, оюутан, залуучуудын дунд үе тэнгийн сургагч багш бэлтгэх, эдгээр сургагч багш нараар дамжуулан тогтмол сургалт зохион байгуулах;

3.1.2 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 2. Эрүүл мэндийн болон эрсдэлтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын халдвартын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг тогтолжуулж, халдварт авах эрсдэлт зан үйлийг өөрчлөх

3.1.2.1. Хепатитийн В, С вирусийн халдвартын шинэ тохиолдол бүрт халдвартамжих замыг тодорхойлох тандалт судалгаа хийх;

3.1.2.2. Вирусийн халдварт авах эрсдэлтэй үйлчилгээ / шивээс хийлгэх, чих, хамар болон бусад эд эрхтнээ цоолуулах/-ээс хепатитийн вирусийн халдварт авах магадлалтайг олон нийтэд таниулах, эдгээр үйлчилгээ үзүүлдэг газруудад халдвартгүйжүүлэлт, ариутгалын горимыг мөрдүүлэх талаар хяналт тавих;

3.1.2.3. Шүдний эмнэлгүүдийн халдвартын сэргийлэлт, ариутгалын үйл ажиллагааг тогтмол үнэлэх;

3.1.2.4. Жирэмсэн эмэгтэйчүүдийг хепатитийн В, С, Д вирусийн халдварт илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулж, хяналтад авах;

3.1.2.5. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын халдвартын сэргийлэлт, хяналтын талаарх мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах;

3.1.3 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 3. Хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, тасралтгүй байдлыг хангах;

3.1.3.1. Хепатитийн А, В вирусийн халдвартын эсрэг дархлаажуулалтад харьяалал үл харгалзан товтолт хугацаанд нь бүрэн хамруулах;

3.1.3.2. Хепатитийн В вирусийн халдвараас сэргийлэх вакцинжуулалтад В вирус илрээгүй иргэдийг хамруулах, дархлал тогтцын түвшинг тогтоох;

3.1.3.3. Дархлаажуулалтын сан байгуулах замаар сайн дурын дархлаажуулалтыг олон нийтэд сурталчилж, хамралтын хүрээг нэмэгдүүлэн, дархлаажуулалт бүхий халдварт өвчинөөс сэргийлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

3.1.4 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 4. Аймгийн хэмжээнд хепатитийн вирусийн халдвартын мэдээлэл бүхий нэгдсэн сан бий болгох

3.1.4.1 Аймгийн хэмжээнд хепатитийн вирусийн халдвартын илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн мэдээлэл бүхий нэгдсэн сан бий болгож, хорт хавдрыг эрт илрүүлэх, эргэн хянах үйл ажиллагаанд ашиглах боломжтой болгох;

Хүрэх үр дүн.

- Хепатитийн А вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг 99%, төрсний дараах 24 цагийн дотор нярайд хийх хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтыг 99%-аас бууруулахгүй байна.

- Эрүүл мэндийн байгууллагын халдвартын хяналтын үйл ажиллагаа тогтмолжиж, сайжирна. Хепатитийн С вирусийн халдвартын шинэ тохиолдлын тоо буурна.

- Аймгийн хэмжээнд хепатитийн вирусийн халдвартын илрүүлэг, оношилгоо, эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн мэдээлэл бүхий нэгдсэн сан бий болно.

3.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.2.1 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 1. Хепатитийн вирусийн халдвартын илрүүлгийг элэгний хатуурал, хорт хавдрын эрт илрүүлэгтэй хамтатган зохион байгуулах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.1.1. Аймгийн хэмжээнд 15-аас дээш насын хүн амд хепатитийн В, С вирусийн халдвартыг илрүүлэх арга хэмжээг дараах үе шаттайгаар зохион байгуулна.

- Хөтөлбөрийн нэгдүгээр үе шат /40-65 насны хүн амд-2017 онд/
- Хөтөлбөрийн хоёрдугаар үе шат /15-39 насны хүн амд-2018 онд/

3.2.1.2.Хепатитийн вирусийн халдварт өртөх өндөр эрсдэлтэй бүлгийн хүн амыг хепатитийн В, С вирусийн халвар илрүүлэх шинжилгээнд тогтмол, давтамжтай хамруулах;

3.2.1.3.Хепатитийн В вирусийн халдвартай эхээс хүүхдэд халвар дамжихаас сэргийлэх зорилгоор төрсний дараа 24 цагийн дотор нярайд хепатитийн В вирусийн эсрэг вакциныг иммуноглобулин (HB-Ig)-тай хавсарч хэрэглэх аргыг эмчилгээнд хэрэглэх санхүүгийн нөөцийг бүрдүүлэх;

3.2.1.4.Хепатитийн В вирусийн халдвартай хүмүүст хепатитийн Д вирусийн эсрэг биеийг тодорхойлох шинжилгээнд хамруулах;

3.2.1.5.ДОХ-ын халдвартай, гемодиализ хийлгэдэг, биеэ үнэлэгч, хоригдол зэрэг өндөр эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхой давтамжтайгаар хепатитийн В, С вирусийн халвар илрүүлэх шинжилгээнд тогтмол хамруулна;

3.2.2 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 2. Лабораторийн чадавхийг сайжруулан үйл ажиллагааг тогтмолжуулж, хепатит вирусийн халвар, элэгний хатуурал, элэгний хорт хавдрын оношилгооны баталгааг хангах чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

3.2.2.1.Хепатитийн вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээг нийгмийн даатгалын санхүүжилтээр орон нутагт хийх асуудлыг судлаж, шийдвэрлэх;

3.2.2.2.Анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг сорьц тээвэрлэх багц, ийлдэс хадгалах хөлдөөгчөөр хангах, сорьц тээвэрлэх асуудлаар нийтийн тээвэр зохицуулалтын байгууллагатай хамтран ажиллах;

3.2.2.3.Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний шатлалд тохирсон хепатитийн вирусийн халварыг илрүүлэх, баталгаажуулах сүүлийн үеийн дэвшилтэт шинжилгээний арга технологийг нэвтрүүлэх;

3.2.3 Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 3. Хепатит вирусийн халдвартай иргэдэд эмчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, эдгэрсэн иргэдийг хяналтанд авах чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.3.1.Хепатитийн вирусийн цочмог болон архаг халвар, түүний шалтгаант элэгний хатуурал, элэгний хорт хавдрын эмчилгээ оношлогооны тусlamж, үйлчилгээний удирдамж зааврыг хэрэгжүүлэх;

3.2.3.2.Хепатитийн В вирусийн халдвартай иргэдэд үнэ төлбөргүй давхар Д вирусийн халвар тодорхойлох шинжилгээнд хамруулах асуудлыг судлах;

3.2.3.3.Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эм зүйч, эрүүл мэндийн даатгалын байгууллагын байцаагч нарыг хепатитийн вирусийн халварын оношлогоо, эмчилгээний шинэчилсэн удирдамж, заавар, эмчилгээний хяналтын цахим программ

ашиглах, эмийг хяналтай олгох асуудлаар сургалтад тогтмол хамруулж, чадавхжуулах;

3.2.3.4. Эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор иргэдийг эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулах асуудлыг аймгийн Засаг даргын сумдын Засаг даргатай нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусгах;

3.2.3.5. Вируст хепатитийн халдвартай болон эмчлэгдэж эдгэрсэн хүмүүсийг холбогдох эрсдэлт хүчин зүйлийн дагуу элэгний хорт хавдараас урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах;

Хүрэх үр дүн

Аймгийн хэмжээнд 15-аас дээш насын хүн амыг хепатитийн В, С вирусийн халвар илрүүлэх шинжилгээнд үе шаттай хамруулж, халдвартай хүн амыг эмчлэн эрүүлжүүлж, халдвартай нь тогтоогдсон хүн амыг урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамруулсан байна.

3.3. Хөтөлбөрийн 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.3.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 1. Хепатитийн вирусийн халвар, элэгний хорт хавдрын тархалтаар судалгаа хийх

3.3.1.1. Эмнэлгийн ажилчид болон бусад эрсдэлт бүлгийнхний дундах хепатитийн бүх төрлийн вирусийн халварын тархалтыг тогтоох, хүн амын дунд хепатитийн вирусийн хавсарсан халдваруудын тархварзүйн судалгааг хийх;

3.3.1.2. Вируст хепатитийн эмчилгээ, үйлчилгээний үр дүн, сөрөг нөлөө, хоруу чанарын талаар нарийвчилсан судалгаа хийх;

3.3.1.3. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд эмч, эмнэлгийн мэргэжилтний дундах эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах, үр дүнг олон нийтэд сурталчиллах, амжилт гаргасан эмч, мэргэжилтэн, ажилтныг алдаршуулах;

Хүрэх үр дүн

Хепатитийн вирусийн халвар, элэгний хорт хавдрын оношилгоо, эмчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлд тусгасан байна.

3.4.1. Хөтөлбөрийн 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.4.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл 1. Төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ачааллыг хуваалцах

3.4.1.1. Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг халварын сэргийлэлт, хяналтын үнэлгээнд хамруулах, зөрчлийг бүртгэх, зөрчлийг арилгахад хяналт тавих;

3.4.1.2.Хүүхдийн байгууллагын барилга байгууламжийг зориулалтаар нь ашиглах, эрүүл ахуй, ариун цэврийн нөхцлийг хангуулах, эрүүл зан үйл төлөвлүүлэх;

3.4.1.3.Эрүүл мэндийн тулгамдсан асуудал хөндсөн, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг тасралтгүй хүргэхэд хэвлэл мэдээллийн байгууллага нийгмийн хариуцлагаа бий болгоход санаачлага гаргах;

3.4.1.4.Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаанд хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, сайн дурынхан болон бусад нийгмийн төлөөллүүдийг татан оролцуулах;

3.4.2.5.Эмчилгээний үр дүн гарсан иргэдийн төлөөллийн орон тооны бус зөвлөлийг сайн дурын үндсэн дээр байгуулж, хамтран ажиллах;

Хүрэх үр дүн.

Хүн амд хепатитийн вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, оношлогоо эмчилгээтэй холбоотой тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй хүргэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ачааллыг хуваалцах нөхцөл бүрдүүлэх;

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 299.900.000 төгрөгийн санхүүжилт шаардлагатай.

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

4.1.1.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө - 198.900.000 сая төгрөг

4.1.2.Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө - 101.000.000 сая төгрөг

4.1.5.Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр;

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, хяналт, шинжилгээ

5.1. Төрийн болон хувийн хэвшлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллага нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 1 дүгээр сард багтаан аймгийн Эрүүл мэндийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

5.2. Эрүүл мэндийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн Эрүүл мэндийн яаманд жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

5.3. Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг хагас, бүтэн жилээр, бүх шатны Засаг дарга Эрүүл мэндийн салбар зөвлөлтэй хамтран өвчтөн, нийгмийн төлөөллийг оролцуулан гүйцэтгэнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, үр дүнгийн биелэлтийг дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлно.

Шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Төгсгөлийн шалгуур
	2015 он	2017 он	2018 он	2020 он
Нийт хүн ам болон зорилтот бүлгийнхний дундах вируст хепатитын талаарх зөв зохицтой мэдлэг, хандлагатай хүмүүсийн эзлэх хувь	15%	35%	45%	>65%
Хепатитийн А вирусийн эсрэг вакцинуулалтын хамралтын хүрээ	95%	98%	99%	>99%
Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, оюутнууд хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь	73.4%	85%	90%	>92%
Цагдаа, цэрэг, онцгой байдлын ажилтнууд, зэрэг өндөр эрсдэлтэй бүлгүүдийг хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтын хамралтын хувь	0	80%	85%	>90%
Нярайг төрсний дараах 24 цагийн дотор хепатитийн В вирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулсан хувь	96.3%	>98%	>99%	>99%
Халдвартын сэргийлэлт хяналт үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын хувь	35%	70%	80%	>90%
Хүн амыг хепатитийн В вирусийн халдвартай тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	0%	>23%	>65%	>80%
Хепатитийн В вирусийн халдвартай хүмүүсийг хепатитын Д вирусийн хамхалдвартай тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	Тодорхойгүй	>60%	>85%	>99%
Хүн амыг хепатитийн С вирусийн халдвартай тодорхойлох шинжилгээнд хамруулсан хувь	0%	>23%	>65%	>80%
Хепатитийн С вирусийн халдвартай эмчилгээнд хамруулах хэрэгтэй хүмүүсийн хувь	<0.5%	75%	>98%	>99%
Хепатитийн С вирусийн эсрэг эмчилгээний горимыг бүрэн дуусгасан өвчтөнүүдээс бүрэн эмчилгээний иргэдийн тоо	Тодорхойгүй	--	--	---
Хепатитийн В вирусийн дан халдвартай хүмүүсийг вирусийн идэвхжил дарангуйлах эмчилгээнд хамруулсан хувь	<0.5%	30%	>35%	>60%
Хяналт, оношилгоо, эмчилгээг хийх эмч, эмнэлгийн мэргэжилтний сургалтанд хамруулсан хувь	Тодорхойгүй	>90%	>90%	>90%

10000 хүн амд ноогдох нийт вируст хепатитийн өвчлөлийн шинэ тохиолдол	0,24	--	--	--
Элэгний хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин	7	6	5	>4

Долоо.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

7.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргаар ахлуулан байгуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга болон Эмнэлгийн тусlamжийн хэлтсийн дарга, холбогдох мэргэжилтнүүд, Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн төлөөлөл, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, халдварт, хавдар, доторын эмчийг оруулна.

7.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэний нийгэм, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүргийг аймгийн Эрүүл мэндийн газар хариуцна.

7.3.Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулна.